



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 587

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.14, 6.1.15, 6.2.10, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5, 17.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 186, 187, 386, 793 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан холбогдох дүрэм, журамдаа зохих өөрчлөлтийг оруулж, Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулахыг уул уурхайн бүтээгдэхүүний бирж, арилжааны төлбөр тооцооны болон клирингийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тус тус үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖ БОЛОН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ (БРОКЕР)-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос уул уурхайн бүтээгдэхүүний бирж (цаашид “бирж” гэх) болон биржийн арилжааны зуучлагч (брокер) (цаашид “брокер” гэх)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих нөхцөл, шаардлагыг тогтоох, түүний үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1-д заасан үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь биржээр арилжаалах бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авахад зуучлах брокерийн үйл ажиллагааг энэ журмаар тавигдсан нэмэлт шаардлагыг хангасан нөхцөлд эрхэлж болно.

1.3.Энэ журамд заасан бирж болон брокер нь үйл ажиллагаагаа байнгын, тогтвортой, тасралтгүй явуулж, ил тод, үр ашигтай, шударга байх, сонирхлын зөрчлөөс сэргийлэх, дотоод хяналтын удирдлагыг үр дүнтэй байлгах зарчмыг баримтална.

1.4.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжаалахтай холбоотой брокерт тавих нэмэлт шаардлагыг Хорооноос баталсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн журмаар зохицуулна.

Хоёр.Бирж болон брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавих шаардлага

2.1.Бирж болон брокерийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 5.1-5.3, 18.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1.биржийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 20 тэрбум төгрөгөөс доошгүй байх;

2.1.2.брокерийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 5 тэрбум төгрөгөөс доошгүй байх;

2.1.3.энэ журамд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

2.1.4.бирж болон брокерийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх.

2.2.Энэ журмын 2.1.1-2.1.2-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байна.

2.3.Биржийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.3.1.бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг зохион байгуулахад шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон тусгай программ хангамжтай байх бөгөөд уг программ хангамж нь дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1.1.харилцагчийн хувийн мэдээлэл гуравдагч этгээдээс нууц байх;

2.3.1.2.зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, шинэчлэх боломжтой байх;

2.3.1.3.олон нийтэд мэдээлэл хүргэх хэсэг буюу нээлттэй самбартай байх;

2.3.1.4.арилжааны хяналтын системтэй байх;

2.3.1.5.аюулгүй байдлыг хангах албан ёсны лицензтэй байх.

2.3.1.6.мэдээллийн нууцлал, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангасан байх.

2.3.2.бирж нь тооцооны үйл ажиллагааг өөрөө эрхлэхээс бусад тохиолдолд үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын системд холбогдсон байх;

2.3.3.бирж нь төлбөрийн үйл ажиллагааг банкаар гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд үнэт цаасны төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын системтэй холбогдсон байх;

2.3.4.системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт буюу онцгой байдлын төлөвлөгөө, нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлтийг хангасан байх;

2.3.5.энэ журмын тавдугаар хавсралтад заасан мэдээллийн технологийн стандартыг хангасан байх.

2.4.Брокерийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.4.1.бирж,клирингийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, программ хангамжийн шаардлагыг тус тус хангасан байх;

2.4.2.харилцагчдыг хүлээн авч үйлчлэх ажлын байрны хэсгийг брокероос бусад ажилтны албан өрөөнөөс тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байх;

2.4.3.арилжаанд оролцогчийн захиалга, биелэлтийг баталгаажуулж, биржид бүртгүүлэх, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, харилцагчид мэдээлэл өгөх, харилцагчийн захиалга өгөх хэсэг (front-end) болон бэк оффис (back office)-ын программ хангамжтай байх.

2.4.4.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд мөнгөн хөрөнгийн номиналь данс эзэмшихэд тавигдах нөхцөл шаардлагыг хангасан байх.

2.5.Бирж, брокерийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэх тохиолдолд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.5.1.хувьцааг худалдан авч буй мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны байх;

2.5.2.шинэ хувьцаа эзэмшигч нь энэ журмын 2.1.4-т заасан шаардлагыг хангасан байх;

2.5.3.хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулсан байх.

2.6.Салбар, төлөөлөгчийн газар байгуулахад дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.6.1.сүүлийн хоёр улиралд Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан;

2.6.2.салбар, төлөөлөгчийн газар нь байнгын үйл ажиллагаа явуулах хаяг, байршил нь тодорхой ажлын байртай, тухайн салбар, төлөөлөгчийн газарт тогтмол ажиллах эрхлэгч мэргэжилтэнтэй байх;

2.6.3.салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

2.6.4.төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны журамтай байх.

2.7.Биржийн үйл ажиллагааг эрхлэх хүсэлт гаргагч энэ журмын тавдугаар хавсралтад заасан MNS ISO/IEC 27001 стандартын сүүлийн хувилбарыг хангаж, хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.

2.8.Нээлттэй хувьцаат компани хэлбэртэй бирж, брокерийн тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдах, барьцаалах, бусад хэлбэрээр шилжүүлэх тохиолдолд энэ журмын 2.5-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

Гурав.Бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн шаардлага

3.1.Бирж нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 7.1-д заасан есөн гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн дөрөв нь хараат бус гишүүн байна.

3.2.Бирж үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэхэд шаардлагатай дараах бүтэц зохион байгуулалттай байна:

3.2.1.уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг зохион байгуулах нэгжтэй байх;

3.2.2.мэдээлэл, технологийн бие даасан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.2.3.дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.2.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх нэгж, эсхүл хариуцсан ажилтантай байх бөгөөд түүний үйл ажиллагаанд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина;

3.2.5.уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан опцион гэрээ, фьючерсийн гэрээний стандартыг тогтоох, арилжаалах нөхцөлийг хангах, арилжаанд хяналт тавих нэгж, эсхүл ажилтантай байх;

3.2.6.уул уурхайн бүтээгдэхүүн, үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн шинжилгээ, судалгаа хийх чиглэлээр мэргэшсэн ажилтан, эсхүл нэгжтэй байх.

3.3.Биржийн төлөөлөн удирдах зөвлөл нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9.2-т зааснаас гадна дараах дүрэм, журмыг Хорооны зөвшөөрлөөр батална.

3.3.1.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

3.3.2.дотоод хяналтын журам;

3.3.3.ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх журам;

3.3.4.эрсдэлийн удирдлагын журам;

3.3.5.ёс зүйн дүрэм;

3.3.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, эсхүл дотоод журам.

3.4. Бирж нь дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг энэ журмын 3.3.2, 3.3.4-т тус тус заасан журамд дэлгэрэнгүй тусгана.

3.5. Биржийн комплайнс болон дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтан нь үйл ажиллагаагаа тусдаа, бие даасан байдлаар явуулах ба ажлаа төлөөлөн удирдах зөвлөлд шууд тайлагнах бөгөөд гүйцэтгэх удирдлагад зөвлөмж хүргүүлж ажиллана.

3.6. Энэ журмын 3.2.3-т заасан дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтан нь үйл ажиллагаандаа зохистой засаглал, хараат бус байх зарчмыг мөрдөж ажиллах ба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.6.1. компанийн үйл ажиллагааны бусад чиг үүргийг гүйцэтгэхгүй, бие даасан байх;

3.6.2. аудитын ажлыг зохих ёсоор төлөвлөх, бүртгэх, хянах, түүнээс гарсан үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг тэмдэглэн хөтөлж, баримтжуулах;

3.6.3. аудитын тайланд онцолсон асуудлуудыг удирдлагад тухай бүр тайлагнаж шийдвэрлүүлэх.

3.7. Брокер үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэхэд шаардлагатай дараах бүтэц зохион байгуулалттай байна:

3.7.1. үндсэн үйл ажиллагааг явуулах хоёроос доошгүй мэргэжилтнээс бүрдсэн нэгжтэй байх;

3.7.2. мэдээлэл, технологийн бие даасан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.7.3. дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.7.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх нэгж, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.7.5. эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журам нь тодорхой, энэ чиглэлээр мэргэжил, туршлагатай хүний нөөцтэй байх.

3.8. Биржийн эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

3.8.1. төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 7.5, 7.6-д тус тус заасан шаардлагыг хангасан байх;

3.8.2. гүйцэтгэх удирдлага нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 8.4-т заасан шаардлагыг хангасан байх;

3.8.3. энэ журамд заасан нэгжийн удирдах албан тушаалтан нь уул уурхай, санхүүгийн салбарт хоёроос доошгүй жил ажилласан туршлагатай, бусад мэргэжилтэн нь уул уурхай, хууль, худалдаа, санхүү, эдийн засаг, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн байх;

3.8.4. тухайн компанид үйлчилгээ үзүүлдэг үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө, хөрөнгийн үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэгч болон өөрийн гишүүн брокерийн компаниудын эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд биш байх;

3.8.5. хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэх удирдлага нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

3.8.6. гүйцэтгэх удирдлага нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах бөгөөд мэргэжилтэн нь ял шийтгэлгүй, компанийн үндсэн ажилтан байх;

3.8.7.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь уул уурхай, санхүү, үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;

3.8.8.хуульд өөрөөр заагаагүй бол мэргэжилтэн нь давхар ажил хавсран эрхэлдэггүй байх.

3.9.Брокерийн эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

3.9.1.энэ журамд заасан нэгжийн удирдах албан тушаалтан нь уул уурхай, санхүүгийн салбарт хоёроос доошгүй жил ажилласан туршлагатай, үндсэн үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэн нь уул уурхай, хууль, худалдаа, эсхүл санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн байх;

3.9.2.тухайн компанид үйлчилгээ үзүүлдэг үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө, хөрөнгийн үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд биш байх;

3.9.3.хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэх удирдлага нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

3.9.4.гүйцэтгэх удирдлага нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

3.9.5.Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээгээгүй, эсхүл хүлээж байгаагүй байх;

3.9.6.хуульд өөрөөр заагаагүй бол мэргэжилтэн нь давхар ажил хавсран эрхэлдэггүй байх;

3.9.7.гүйцэтгэх удирдлага, үндсэн үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэн нь уул уурхай, санхүү, үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;

3.9.8.зуун хувийн гадаадын хөрөнгө оруулалттай брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд мэргэжилтний 70-аас доошгүй хувь нь Монгол Улсын иргэдээс бүрдсэн байх;

3.9.9.Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангасан байх.

3.10.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 5.8-д заасан арилжаа эрхлэх байгууллагын хувьд энэ журамд заасан уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг зохион байгуулах нэгж нь бусад нэгжээс үйл ажиллагаагаа тусгаарласан, бие даасан байна.

3.11.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх нэгж нь энэ журмын 3.7.1-д заасан нэгжээс тусдаа, бие даасан байна.

3.12.Энэ журмын 3.2.2-3.2.4-т заасан нэгж, эсхүл ажилтны чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

3.13.Энэ журмын 3.7.1-3.7.5-д заасан нэгжийн ажилтан нь бусад нэгжийн үйл ажиллагааг хавсран эрхлэхгүй бөгөөд тусдаа, бие даасан, хараат бус зарчмыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллана.

Дөрөв.Бирж болон брокерийн үйл ажиллагаа

4.1.Бирж нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9.1-д заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, биржийн арилжааг шударга, ил тод, нээлттэй, хараат бусаар зохион байгуулах зарчмыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөнө.

4.2.Бирж нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, энэ журам болон Хорооноос тогтоосон холбогдох журмын шаардлагыг тогтмол биелүүлэх ба уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн тогтвортой, үр ашигтай байдлыг хангаж ажиллана.

4.3.Бирж нь санхүүгийн зах зээлийн гэнэтийн хямрал, давагдашгүй хүчин зүйлийн үед авч хэрэгжүүлэх бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.

4.4.Бирж нь брокероос ирүүлсэн захиалгыг үнэ ханш, цаг хугацааны дарааллын дагуу арилжааг шударгаар зохион байгуулж ажиллах бөгөөд арилжаа шударга, сонирхлын зөрчилгүй, ил тод явагдаж буй эсэхэд байнгын хяналт тавина.

4.5.Бирж нь Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс” болон түүнд нийцүүлсэн дүрэм, журам, заавар аргачлалыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

4.6.Бирж нь энэ журмын тавдугаар хавсралтад заасан мэдээллийн технологийн стандартыг үйл ажиллагааныхаа явцад тогтмол хангана.

4.7.Брокер нь уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр харилцагчийг тогтмол хангаж ажиллана.

4.8.Брокер нь Хорооноос тогтоосон “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөнө.

4.9.Брокер нь өөрийн харилцагчийн арилжааг гүйлгээний төрөл, хэмжээний хувьд зах зээлийг харгалзан үзсэний үндсэн дээр байж болох хамгийн сайн нөхцөлтэйгөөр гүйцэтгэх зарчмыг баримтална.

4.10.Брокер нь хууль тогтоомжийн дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой хийсэн судалгаа, өгсөн зөвлөгөө болон авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг таваас доошгүй жилийн хугацаагаар хадгалах ба бүртгэлийг аюулгүй найдвартай хадгалах үйл ажиллагааг дотоод дүрэм, журмаар тодорхой зохицуулсан байна.

4.11.Бирж, брокерийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд Хороонд урьдчилан мэдэгдэж, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, нэмж гаргасан хувьцааг худалдан авах этгээд нь холбогдох хууль, энэ журам болон Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангаж буй эсэхээ тогтоолгосны дараа өмчлөх эрх шилжих, гүйлгээ хийх ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.12.Бирж, брокерийн эрх бүхий албан тушаалтныг томилох тохиолдолд Хороонд урьдчилан мэдэгдэж, шинээр томилогдож буй этгээд нь холбогдох хууль, энэ журам болон Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангаж буй эсэхээ тогтоолгосны дараа томилох ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.13.Гүйцэтгэх удирдлагаар томилохоор санал болгож байгаа этгээд нь энэ журмын 2.1.4-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд гүйцэтгэх захирлаар томилох өөр этгээдийг нэг сарын дотор санал болгоно.

4.14.Бирж, брокер нь өөрийн оршин байгаа газрын хууль ёсны хаягийг өөрчлөх тохиолдолд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор энэ журмын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргасан өргөдлийг Хороонд ирүүлнэ.

4.15.Хороо энэ журмын 4.14-т заасны дагуу хаяг байршлын өөрчлөлт, холбогдох ажлын байр нь хууль болон энэ журмын шаардлага хангаж байгаа эсэхийг нягталж, ажлын таван өдөрт багтаан хариуг албан бичгээр мэдэгдэнэ.

4.16.Бирж, брокер оноосон нэрээ өөрчлөх тохиолдолд Хороонд урьдчилан мэдэгдэж, Иргэний хуулийн 27.3-т “Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй” гэж заасныг болон харилцагч, олон нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй байх шаардлагыг хангаж буй эсэхээ тогтоолгосны үндсэн дээр оноосон нэрийн өөрчлөлтийг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

4.17.Энэ журмын 4.16-д заасан шаардлагыг хангаж бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн тохиолдолд зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, шинээр олгон, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

4.18.Бирж, брокер нь салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хязгаарлах, байршлыг нь өөрчлөх тухай бүрд эрх бүхий этгээдийн шийдвэрийг гаргуулж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Хороонд мэдэгдэнэ.

4.19.Бирж, брокерийн гүйцэтгэх удирдлагыг өөрчлөн томилох, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх болон салбар, төлөөлөгчийн газар байгуулагдах, оноосон нэр өөрчлөх асуудлыг хууль болон энэ журмын шаардлага хангасан гэж Хорооноос хариу өгсөн тохиолдолд хүсэлт гаргагч нь бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох өөрчлөлтийг хийлгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн шинэчилсэн хуулбарыг ажлын 15 өдөрт багтаан Хороонд хүргүүлж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд зохих тэмдэглэгээг хийлгэнэ.

4.20.Нээлттэй хувьцаат компани хэлбэртэй бирж, брокерийн хувьд энэ журмын 4.11 дэх заалт хамаарахгүй бөгөөд нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тохиолдолд Хорооны үнэт цаасны бүртгэлийн журмыг дагаж мөрдөнө.

4.21.Бирж, брокер нь энэ журмын наймдугаар хавсралтад заасан төлбөр, хураамжийн дээд хязгаарыг холбогдох дүрэм, журамдаа тусгаж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

Тав.Мэдээллийн ил тод байдал

5.1.Бирж, брокер нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль болон энэ журамд заасан мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүйгээр тогтоосон хугацаанд болон тухай бүрд Хороо, харилцагч болон олон нийтэд хүргэнэ.

5.2.Биржийн хувьд төлөөлөн удирдах зөвлөл, брокерийн хувьд гүйцэтгэх удирдлага нь мэдээлэл, тайлагналыг энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавина.

5.3.Бирж, брокер жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дотор, хагас жил, улирлын санхүүгийн тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд тогтмол хүргүүлнэ.

5.4.Бирж нь жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг гаргах бөгөөд жилийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

5.5.Энэ журмын 5.4-т заасан жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгана:

5.5.1.компанийн бүтэц, зохион байгуулалт, засаглал, хүний нөөц;

5.5.2.ашиг, орлогод нөлөөлсөн хүчин зүйлс;

5.5.3.үйл ажиллагааны ашигт ажиллагаа, зардлын харьцаа үзүүлэлтүүд;

5.5.4.арилжааны хэмжээ, төрөл, шимтгэл, хураамж;

5.5.5.бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны бодлого, стратегийн хэрэгжилт;

5.5.6.Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт болон хагас жилийн санхүүгийн тайлан;

5.5.7.жилийн үйл ажиллагааны тайлангийн хувьд ашиглаж буй программ хангамж, систем, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдалд хийсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ;

5.5.8.сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл, тухайн хэлцэлд оролцогч талууд;

5.5.9.жилийн үйл ажиллагааны тайлангийн хувьд эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, дотоод аудитын үйл ажиллагаа;

5.5.10.холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, түүний хэрэгжилт;

5.5.11.бусад мэдээлэл.

5.6.Нээлттэй хувьцаат компани хэлбэртэй биржийн хувьд энэ журмын 5.4 дэх заалт хамаарахгүй бөгөөд жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг тайлагнахдаа Хорооны үнэт цаасны бүртгэлийн журмыг дагаж мөрдөнө.

5.7.Бирж, брокер нь харилцагч, олон нийтэд дараах мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр мэдээлнэ:

5.7.1.биржийн хувьд компанийн тав ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй нөлөө бүхий этгээдийн талаарх мэдээлэл, түүний өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээ;

5.7.2.бүтэц, зохион байгуулалтад орсон өөрчлөлт;

5.7.3.үндсэн үйл ажиллагааны танилцуулга, санхүүгийн тайлан, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц хэлцлийн талаар;

5.7.4.эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт;

5.7.5.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд тухай бүр мэдээлэхээр заасан мэдээлэл;

5.7.6.арилжааны программ хангамжийг ашиглахтай холбоотой заавар, зөвлөмж, гарын авлага;

5.7.7.олон нийттэй харилцах утас, цахим шуудан, олон нийтийн сүлжээний хаяг, үйл ажиллагаа явуулж буй хаяг байршил;

5.7.8.биржийн хувьд арилжааны шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;

5.7.9.брокерийн хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;

5.7.10.харилцагчийн санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл;

5.7.11.дотоод дүрэм, журамд заасан бусад мэдээлэл.

“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-ын нэгдүгээр хавсралт

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН БОЛОН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ (БРОКЕР)-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр						
Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан уу?	Тийм О		Үгүй О			
<i>Тийм бол дараах мэдээллийг бөглөнө үү.</i>						
Бизнесийн аль салбарт үйл ажиллагаа явуулж байсан бэ?						
Ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан бэ?						
Өмнө нь тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлж байсан уу?	Тийм О		Үгүй О			
Тийм бол хэдэн онд?						
Татгалзсан шалтгаан?						
1. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлөө сонгоно уу.						
<input type="radio"/> Төрөл 1 Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн						
<input type="radio"/> Төрөл 2 Биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн						
I. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ						
Үүсгэн байгуулагч этгээд нь аль болохыг сонгоно уу.			<input type="radio"/> Хуулийн этгээд <input type="radio"/> Иргэн			
1. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийн үнэн зөв бөглөнө үү.						
Хуулийн этгээдийн нэр	Монгол					
	Англи					
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="radio"/> Хувьцаат компани <input type="radio"/> компани			<input type="radio"/> Хязгаарлагдмал хариуцлагатай		

Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="radio"/> Дотоодын <input type="radio"/> Гадаадын						
Улсын бүртгэлийн дугаар							
Регистрийн дугаар							
Үйл ажиллагааны цэвэр ашиг	₮						
Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө						₮	
Хаяг байршил	Аймаг/ хот						
	Сум/дүүрэг						
	Баг/хороо						
	Гудамж, байр						
	Тоот						
Холбоо барих утас							
Цахим хуудас							
Цахим шуудангийн хаяг							
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?				Тийм	<input type="radio"/>	Үгүй	<input type="radio"/>
Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.							
Оноосон нэр							
Компанийн хэлбэр	<input type="radio"/> Хувьцаат компани			<input type="radio"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани			
Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох				<input type="radio"/> толгой <input type="radio"/> хараат <input type="radio"/> охин <input type="radio"/> зэргэлдээ			
Байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр		
Үйл ажиллагааны төрөл							
Хаяг	Аймаг/ хот						
	Сум/дүүрэг						
	Баг/хороо						
	Гудамж, байр						
	Тоот						
Холбоо барих утас:							
Цахим хуудас:							
Цахим шуудангийн хаяг:							
2. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол доорх мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.							
Овог							
Нэр							
Регистрийн дугаар							

Албан ёсны хаяг байршил					
Эрхэлж байгаа ажил, албан тушаал					
Ажлын хаяг					
Эзэмшсэн мэргэжил					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	₮				
Харилцах дансны үлдэгдэл	₮				
Хадгаламжийн дансны үлдэгдэл	₮				
II. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ					
Хуулийн этгээдийн нэр					
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	О Хувьцаат компани		О Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
Хөрөнгө оруулалтын хэлбэр	О Дотоодын		О Гадаадын		
Улсын бүртгэлийн дугаар					
Регистрийн дугаар					
Хаяг байршил	Аймаг/ хот				
	Сум/дүүрэг				
	Баг/хороо				
	Гудамж, байр				
	Тоот				
	Холбоо барих утас				
Цахим хуудас					
Цахим шуудангийн хаяг					
О Харилцах	Банкны нэр				
	Дансны дугаар				
	Валютын төрөл				
	Үлдэгдэл		₮	₮	
О Хадгаламж	Банкны нэр				
	Дансны дугаар				
	Валютын төрөл				
	Үлдэгдэл		₮	₮	
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:					
Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/оноосон нэр	Хувьцааны тоо (ш)	Хувьцааны төрөл		ХНХ-н хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
		О ДЭХ	О ЭХ		
		О ДЭХ	О ЭХ		
		О ДЭХ	О ЭХ		
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)</i>					
Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл:					
ТУЗ-тэй байх эсэх	Тийм О	Үгүй О	Бүрэлдэхүүний тоо		

Дотоод хяналтын нэгжтэй байх эсэх		Тийм О	Үгүй О					
Нийт ажилтан, албан хаагчдын тоо		Эрэгтэй ажилтны тоо						
		Эмэгтэй ажилтны тоо						
Албан тушаал	Овог	Нэр	Хүйс	Харьяалал	РД	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга								
ТУЗ-ийн гишүүн								
Дотоод хяналтын нэгжийн дарга								
Дотоод хяналтын нэгжийн гишүүн								
Гүйцэтгэх захирал								
Нягтлан бодогч								
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг удирдах ажилтан бүрээр бичнэ.)</i>								
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл								
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт		Худалдан авсан		Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮	
			О		О			
			О		О			
<i>Тэмдэглэл: (Үйл ажиллагааны төрлөөс хамааран шаардлага хангасан техник, тоног төхөөрөмж, программ хангамжтай байна. Дээрх мэдээллийг техник, тоног төхөөрөмж бүрээр бичнэ.)</i>								
Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт		Худалдан авсан		Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮	
			О		О			
			О		О			
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг программ хангамж бүрээр бичнэ.)</i>								
Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төлөвлөлт								
Үзүүлэлтүүд					Он	Он	Он	
Харилцагч үйлчлүүлэгчдийн тоо								
Эх үүсвэрийн өртөг ₮								
Нийт орлого ₮								
Нийт зарлага ₮								
Хүлээгдэж буй ашиг ₮								
Өөрийн хөрөнгийн өгөөж ₮								
Активын өгөөж ₮								

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-ын хоёрдугаар хавсралт

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН БОЛОН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ (БРОКЕР)-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР, ОНООСОН НЭР, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр		
Өргөдөл/хүсэлт гаргагч зохицуулалттай этгээдийн нэр							
Регистрийн дугаар							
Зөвшөөрлийн төрлийг сонгоно уу.							
<input type="radio"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах <input type="radio"/> Салбар, төлөөлөгчийн газар байгуулах <input type="radio"/> Компанийн оноосон нэр өөрчлөх <input type="radio"/> Гүйцэтгэх захирлыг томилох, өөрчлөх							
Тэмдэглэл: (тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина)							
1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах							
<input type="radio"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах <input type="radio"/> Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах							
A. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах							
Оноосон нэр /Овог, нэр	РД	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)	
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)							
B. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах							
Этгээд	Оноосон нэр	Овог нэр	Харьяалал	РД	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
Хуулийн этгээд							
Иргэн							
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)							
2. Салбар, төлөөлөгчийн газар байгуулах							
Компанийн оноосон нэр							
Салбар байгуулах шийдвэр	Он		Сар		Өдөр	Дугаар	
Нэгжийн хэлбэр	<input type="radio"/> Салбар			<input type="radio"/> Төлөөлөгчийн газар			

Чиглэл	
Хаяг байршил	Аймаг/ хот
	Сум/дүүрэг
	Баг/хороо
	Гудамж, байр
	Тоот
	Холбоо барих утас
Цахим хуудас	
Цахим шуудангийн хаяг	

3. Салбар, төлөөлөгчийн газрын ажилтны мэдээлэл

Нэгжийн нийт ажилтан, албан хаагчдын тоо	Эрэгтэй ажилтны тоо							
	Эмэгтэй ажилтны тоо							
Албан тушаал	Овог	Нэр	Хүйс	Харьяалал	РД	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг ажилтан бүрээр бичнэ.)

Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл

Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
		О	О		
		О	О		

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг техник, тоног төхөөрөмж бүрээр бичнэ.)

Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
		О	О		
		О	О		

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг программ хангамж бүрээр бичнэ.)

4. Компанийн оноосон нэр өөрчлөх

Компанийн хуучин нэр	Регистрийн дугаар
Компанийн шинэчилсэн нэр	
Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан, үндэслэл	

5. Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах

Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	РД	Утасны дугаар

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг


огноо

“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-ын гуравдугаар хавсралт

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД МЭРГЭШСЭН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	
Овог нэр:	
Регистрийн дугаар:	
Хүйс	
Иргэний харьяалал:	
Хүсэлт гаргагчид эрхлэх албан тушаал:	
Оршин суугаа газрын хаяг:	
Гар утасны дугаар:	
Цахим шуудангийн хаяг:	



2. Боловсрол (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ)

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн огноо	Төгссөн огноо	Диплом, гэрчилгээний дугаар

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Шалтгаан

4. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага бусад мэргэшсэн хүний нөөцийн холбогдох этгээдийн байдал

№	Таны хэн болох	Овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

Миний бие дээр мэдүүлсэн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв болохыг баталж байна.

Тодорхойлолт гаргасан:

/...../ /.....//...../.....
 /овог, нэр/ /гарын үсэг/ /огноо/

“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч
/(брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага,
түүнд хяналт тавих журам”-ын дөрөвдүгээр хавсралт

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН БОЛОН БИРЖИЙН
АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ (БРОКЕР)-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЭТГЭЭДИЙН ХАЯГ БАЙРШИЛ ӨӨРЧЛӨХ ТОХИОЛДОЛД ИРҮҮЛЭХ
ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

1. Шинэ хаяг, байршлын талаарх мэдээлэл		
Наяг, байршил өөрчилсөн эрх бүхий этгээдийн шийдвэрийн огноо, дугаар		_____ он _____ сар _____ өдөр Дугаар _____
Хаяг байршил	Аймаг/ хот	
	Сум/дүүрэг	
	Баг/хороо	
	Гудамж, байр	
	Тоот	
	Холбоо барих утас	

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-ын тавдугаар хавсралт

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТЫН ЖАГСААЛТ

№	Стандартын нэр	
1.	MNS 5969	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага
2.	MNS 6248	Программ хангамжийн боловсруулалт-Программ хангамжийн бүтээгдэхүүний чанарын шаардлага болон үнэлгээ (Square)-чанарын шаардлага
3.	MNS 6197	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга-Мэдээллийн технологийн сүлжээний аюулгүй байдал-1-р хэсэг: Сүлжээний аюулгүй байдлын удирдлага
4.	MNS 6242-2	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга-Мэдээллийн технологийн сүлжээний аюулгүй байдал-2-р хэсэг: Сүлжээний аюулгүй байдлын архитектур
5.	MNS ISO 12207	Программ хангамж боловсруулах үйл ажиллагааны циклүүд
6.	MNS ISO 19011	Менежментийн тогтолцооны аудитын заавар
7.	MNS ISO/IEC 27001	Мэдээллийн технологи: Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-Шаардлага
8.	MNS ISO/IEC 13335-1	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн ба холбооны технологийн байдлын удирдлага-1-р хэсэг: Мэдээлэл холбооны технологийн аюулгүй байдлын үндсэн ойлголтууд болон загварууд
9.	IEEE 829	Программ хангамж турших болон баримт бичигжүүлэлтийн стандарт
10.	MNS 6498	Харилцаа холбооны тоног төхөөрөмжид тавих аюулгүй байдлын шаардлага
11.	MNS 6528	Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтэц

“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-ын зургаадугаар хавсралт

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэ журмын нэгдүгээр хавсралт дахь өргөдөл;	
2	Үндсэн үйл ажиллагаанд ашиглах программын танилцуулга;	
3	Биржийн үйл ажиллагаа эрхлэх дотооддоо мөрдөх журмууд;	
4	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (e-mongolia.mn-аас авсан хүчинтэй лавлагаа), хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;	
5	Эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдийн энэ журмын гуравдугаар хавсралт дахь тодорхойлолт болон Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан тохиромжтой этгээдийн шалгуур хангасныг нотлох баримт бичиг;	
6	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт;	
7	Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагаас сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцохгүй, сонирхлын зөрчил үүсгэхгүй талаарх баталгаа;	
8	Үнэт цаасны арилжааны, клирингийн болон төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээний төсөл;	
9	Компанийн гурван жилийн бизнес төлөвлөгөө;	
10	Энэ журмын 3.3-т заасан журмууд;	
11	Техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэсэн талаарх танилцуулга;	
12	Үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалт, мэргэшсэн хүний нөөцийн талаар энэ журмын гуравдугаар хавсралт дахь тодорхойлолт болон холбогдох баримт бичиг;	
13	Хороонд хүсэлт гаргахаас өмнөх хугацаанд үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдийн хувьд сүүлийн 3 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, дүгнэлт, шинээр үүсгэн байгуулсан бол эхлэлтийн баланс;	
14	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системийн талаарх танилцуулга;	
15	Улсын тэмдэгтийн хураамж, Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт;	
16	Итгэмжлэл олгож бүртгэх агуулах, терминал, тээвэр логистик, шинжилгээний лабораторийн талаарх мэдээлэл.	

“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-ын долоодугаар хавсралт

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ
(БРОКЕР)-ИЙН ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ИРҮҮЛЭХ
БАРИМТ БИЧИГ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэ журмын нэгдүгээр хавсралт дахь өргөдөл;	
2	Үндсэн үйл ажиллагаанд ашиглах программын танилцуулга;	
3	Брокерийн үйл ажиллагаа эрхлэх дотооддоо мөрдөх журмууд;	
4	Эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдийн энэ журмын гуравдугаар хавсралт дахь тодорхойлолт болон Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан тохиромжтой этгээдийн шалгуур хангасныг нотлох баримт бичиг;	
5	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (e-mongolia.mn-аас авсан хүчинтэй лавлагаа), хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;	
6	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт;	
7	Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагаас сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцохгүй, сонирхлын зөрчил үүсгэхгүй талаарх баталгаа;	
8	Техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэсэн талаарх бусад этгээдтэй байгуулсан гэрээ, дэлгэрэнгүй танилцуулга;	
9	Хороонд хүсэлт гаргахаас өмнөх хугацаанд үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдийн хувьд сүүлийн 3 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, дүгнэлт, шинээр үүсгэн байгуулсан бол эхлэлтийн баланс;	
10	Компанийн гурван жилийн бизнес төлөвлөгөө;	
11	Арилжааны төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, харилцагчид мэдээлэл өгөх бэк оффис (back office), фронт оффис (front office)-ын программын танилцуулга;	
12	Хорооноос баталсан “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”-ын шаардлагыг сүүлийн дөрвөн улирал дараалан хангасан мэдээлэл;	
13	Мөнгөн хөрөнгийн номиналь данс эзэмшихэд тавигдах нөхцөл, шаардлагыг хангасан талаарх мэдээлэл;	
14	Үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалт, мэргэшсэн хүний нөөцийн талаар энэ журмын гуравдугаар хавсралт дахь тодорхойлолт болон холбогдох баримт бичиг;	
15	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой	

	тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системийн талаарх танилцуулга;	
16	Харилцагчдад үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ, харилцагчтай байгуулах гэрээний төсөл;	
17	Улсын тэмдэгтийн хураамж, Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт;	
18	Ажлын байрны тодорхойлолт, ажлын байр нь компанийн өөрийн өмчлөлийн байр бол үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (e-mongolia.mn-аас авсан хүчинтэй лавлагаа), түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;	
19	Итгэмжлэл олгож бүртгэх агуулах, терминал, тээвэр логистик, шинжилгээний лабораторийн талаарх мэдээлэл.	

“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-ын наймдугаар хавсралт

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР, ХУРААМЖ

1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйлчилгээний хураамж

№	Үйлчилгээний төрөл	Үнийн дүн	
1	Гишүүнчлэлийн хураамж		
1.1	Өргөдлийн хураамж	500,000 төгрөг	
1.2	Элсэлтийн хураамж	15,000,000 төгрөг	
1.3	Гишүүнчлэлийн хураамж	375,000 төгрөг (улирал бүр)	
1.4	Терминал ашигласны эрх тус бүрийн хураамж (эхний эрх үнэ төлбөргүй)	195,000 төгрөг (улирал бүр)	
2	Арилжааны шимтгэл		
		Зуучлагчгүй гэрээ	Зуучлагчтай гэрээ
2.1	Худалдагч тал	1 багц 100,000 төгрөг	
2.2	Худалдан авагч тал	Тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.1 хувь	Тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.08 хувь

2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйлчилгээний төлбөр, хураамж

№	Үйлчилгээний төрөл	Үнийн дүн
1	Спот гэрээний арилжаа	
1.1	Худалдагч талаас	0.5 хувиас ихгүй
1.2	Худалдан авагч талаас	1 багц тутамд 200,000 төгрөгөөс ихгүй
2	Форвард гэрээний арилжаа	
1.1	Худалдагч талаас	0.5 хувиас ихгүй
1.2	Худалдан авагч талаас	1 багц тутамд 200,000 төгрөгөөс ихгүй

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА, ТӨЛБӨР, ТООЦОО ХИЙХ ЕРӨНХИЙ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Уул уурхайн бүтээгдэхүүний бирж (цаашид “Бирж” гэх)-ийн арилжааны гэрээнд тавигдах шалгуурыг тогтоох, арилжааны хэлцлийн үр дүнд үүсэх тооцоог боловсруулан баталгаажуулах, төлбөр гүйцэтгэх даалгаврыг төлбөр тооцооны байгууллагад илгээх, төлбөрийн эрсдэлийг системийн хэмжээнд удирдах, арилжаа, төлбөр, тооцоо, клирингийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Уул уурхайн бүтээгдэхүүний спот болон форвард гэрээний арилжаа, төлбөр, тооцооны харилцааг энэ журмаар, фьючерс, опцион гэрээний арилжаа, төлбөр, тооцооны харилцааг энэ журам болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос баталсан үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмаар тус тус зохицуулна.

1.3.Биржийн арилжаа зохион байгуулах, төлбөр, тооцоо гүйцэтгэхтэй холбоотой энэ журмаар зохицуулснаас бусад нарийвчилсан харилцааг үнэт цаасны арилжаа эрхлэх болон клирингийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудаас баталсан журмаар зохицуулна.

Хоёр.Биржийн арилжааны гэрээнд тавигдах шалгуур

2.1.Биржээр арилжаалах спот гэрээний хувьд дараах шалгуурыг хангасан байна:

2.1.1.бүтээгдэхүүнийг арилжааны үр дүнд тогтсон үнээр шууд, биет байдлаар нийлүүлэх;

2.1.2.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 12.6-д заасны дагуу спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүн нь биржийн итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршиж, бүртгэгдсэн байх;

2.1.3.уул уурхайн бүтээгдэхүүнийг биржийн итгэмжлэгдсэн агуулах, терминалаас худалдан авагчид нийлүүлэх хугацаа 30 хоногоос дээшгүй байх;

2.1.4.худалдан авагч тал тодорхой байх.

2.2.Биржээр арилжаалах форвард гэрээний хувьд дараах шалгуурыг хангасан байна:

2.2.1.тогтоосон хугацаанд, тогтсон үнэ, нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх;

2.2.2.худалдан авагч тал тодорхой байх.

Гурав.Биржийн үйл ажиллагаа

3.1.Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй, ил тод, оролцогчдын тэгш эрхийг хангасан байдлаар зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох, арилжаалагдаж буй уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, гэрээний мэдээллийг арилжаанд оролцогчид болон олон нийтэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг хангаж ажиллана.

3.2.Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны гэрээний стандарт, нөхцөл, шаардлагыг тогтоож, хяналт тавьж, мөрдүүлнэ.

3.3.Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжаатай холбоотой зах зээлийг урвуулан ашиглах, үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, төлбөр тооцооны системд доголдол үүсэх зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор арилжааны бодит цагийн хяналт тавина.

3.4.Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд ашиг сонирхлын зөрчил үүссэн, зах зээлийг урвуулан ашигласан нөхцөл байдал үүссэн гэж үзсэн тохиолдолд тухайн арилжаатай холбоотой мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт Хороонд нэн даруй хүргүүлнэ.

3.5.Бирж нь гэрээнд заасан хүргэлт хийх хугацаанд биетээр хүргэх суурь хэрэгслийн нийлүүлэлтийн тоо хэмжээг тооцоолж гаргана.

Дөрөв.Клирингийн байгууллагын үйл ажиллагаа

4.1.Клирингийн байгууллага нь ил тод засаглалтай байх ба зах зээлийн найдвартай, үр ашигтай байдлыг дэмжих, эрсдэлийг бууруулах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.

4.2.Клирингийн байгууллага нь төлбөр түргэн гүйцэтгэх, үйл ажиллагааны, төлбөрийн чадварын болон бусад эрсдэлийг иж бүрэн удирдах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байна.

4.3.Клирингийн байгууллага нь клирингийн үйл ажиллагаатай холбоотой оролцогчдын төлбөрийн чадварын эрсдэлийг тооцоолох, хянах, удирдах, клирингийн гишүүн бүрийн төлбөрийн чадварын эрсдэлийг хаах, барагдуулах хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байна.

4.4.Клирингийн байгууллага нь ирээдүйд гүйцэтгэх төлбөрийн болон нийлүүлэлтийн үүрэг биелэхгүй байх эрсдэлийг тооцоолж брокероос барьцаа шаардана.

4.5.Брокер нь клирингийн байгууллагын энэ журмын 4.4-т заасны дагуу шаардсан барьцааг тухайн хэлцэлд оролцож буй харилцагчаас дэнчин (маржин) шаардах замаар бүрдүүлж болно.

4.6.Худалдан авагчаар шалгарсан этгээдийн дэнчинг арилжааны гэрээний төлбөрийн нэг хэсэгт тооцож болно.

4.7.Клирингийн байгууллага нь барьцаанд шаардах мөнгөн хөрөнгийг тооцоолох эрсдэлд суурилсан тусгай аргачлал, загварыг баталж үйл ажиллагаандаа мөрдөнө.

4.8.Клирингийн байгууллага нь брокерийн байршуулсан барьцаа хөрөнгийг харилцагч тус бүрээр, өөрийн хөрөнгөөс тусдаа хадгалах бөгөөд зөвхөн тухайн брокерийн төлбөрийн үүргийг баталгаажуулах, гүйцэтгэхэд ашиглана.

4.9.Клирингийн байгууллага нь уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаатай холбоотой үүсэх системийн эрсдэлийг удирдах үүрэгтэй.

Тав.Төлбөр, тооцооны байгууллагын үйл ажиллагаа

5.1.Төлбөр, тооцооны байгууллага нь клирингийн байгууллагаас ирүүлсэн даалгаврын дагуу худалдан авагчаас төлөх төлбөрийг худалдагчийн дансанд шилжүүлнэ.

5.2.Төлбөр, тооцооны байгууллага нь төлбөр төлөгдсөн тайлангийн дагуу зохих санхүүгийн бүртгэлийг гүйцэтгэн гүйлгээг баталгаажуулна.

5.3.Төлбөр, тооцооны байгууллага нь арилжааны төлбөрийн гүйлгээг тухайн арилжаа явагдсанаас хойш гэрээнд заасан нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ.

5.4.Спот, форвард гэрээний арилжааны дэнчинг биржийн тусгайлан нээсэн банкны системд нөлөө бүхий арилжааны банкин дахь дансанд байршуулах бөгөөд бирж нь дэнчинг өөрийн хөрөнгөөс тусдаа, харилцагч тус бүрээр бүртгэж, зөвхөн тухайн харилцагчийн төлбөрийн үүргийг баталгаажуулах, гүйцэтгэхэд ашиглана.

Зургаа.Эрсдэлийн удирдлага

6.1.Клирингийн үйл ажиллагаанаас санхүүгийн системд үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор клирингийн байгууллага нь эрсдэлийн санг байгуулна.

6.2.Клирингийн байгууллага нь эрсдэлээс хамгаалах санг хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувиас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгөөр байгуулна.

6.3.Эрсдэлийн сангийн хөрөнгийг зөвхөн онцгой нөхцөл байдал үүсэх, өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас клирингийн гишүүдэд учруулсан хохирлыг барагдуулах, клирингийн байгууллагын гишүүд төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зах зээлд учирсан эрсдэлийг хаах зорилгоор зарцуулна.

6.4.Эрсдэлийн сангийн хөрөнгийг банкны системд нөлөө бүхий банканд тусгайлан данс нээж байршуулах бөгөөд сангийн зарцуулалт, үлдэгдлийг улирал тутам Хороонд хүргүүлнэ.

6.5.Клирингийн байгууллага нь эрсдэлийн удирдлагын нэгжтэй байх бөгөөд зах зээлд оролцогчдын төлбөрийн чадварыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, удирдах хүрээнд дараах үүргийг хэрэгжүүлнэ:

6.5.1.клирингийн үйл ажиллагаанд учирч болох (зах зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл) эрсдэлийн удирдлага, бодлогыг боловсруулж мөрдөх;

6.5.2.клирингийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах төлөвлөгөөтэй байх;

6.5.3.уул уурхайн бүтээгдэхүүний зохицуулалттай зах зээлийг шинжилж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаарх зөвлөмжөөр бирж, төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагыг хангах;

6.5.4.клирингийн гишүүдийн барьцааг өдөр бүр тооцоолох бөгөөд барьцааны хувь хэмжээг төлбөрийн чадварын эрсдэлтэй уялдуулж тогтоох;

6.5.5.клирингийн гишүүдийн төлбөрийн чадварын эрсдэлийг удирдахын тулд эрсдэл багатай барьцааг хүлээн зөвшөөрч, үнэ цэнийн бууралт, төвлөрлийн хязгаар зэргийг харгалзан тогтоох;

6.5.6.клирингийн үйл ажиллагааны эрсдэл, түүнээс гарсан алдагдлын талаарх мэдээллийг бүртгэх, хадгалах;

6.5.7.олон улсын жишигт нийцсэн эрсдэлийн үнэлгээ, стресс тест зэрэг тоон болон чанарын аргачлал, зөвлөмжийг гаргаж, оролцогчдын төлбөрийн эрсдэлийг бууруулах бодлогыг баримтална.

6.6.Спот, форвард гэрээний арилжааны хувьд бирж нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд өөрийн хөрөнгийн 3 хувиар эрсдэлийн санг байгуулна.